



SUSTAINABLE
PLASTIC
RECYCLING
IN MONGOLIA

switchasia
GRANTS PROGRAMME



VUV
TGM



УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБА



ХОГОО АНГИЛАХ
ХӨДӨЛГӨӨН
АРИУЛАХ АНГИЛЫН АШУУЛАЛ



БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН

ХОГ АНГИЛАХ

ТУХАЙ ЗААВАРЧИЛГАА

ОФФИСЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАВ

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилтээр Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд боловсруулан хэвлэв. Гарын авлагад орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН
ХОГ АНГИЛАХ
ТУХАЙ ЗААВАРЧИЛГАА

УЛААНБААТАР
2021 ОН

АГУУЛГА

1. Хог хаягдлаа ангилах 10 шалтгаан
2. Хэрхэн хогоо ангилах вэ?
3. Ангилсан дахивраа хаана тушаах вэ?
4. Хог хаягдлыг бууруулах бусад арга замууд
5. Хог хаягдалтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллага олон нийтийн бүлгүүдийн холбоосууд

10 ШАЛТГААН

Хог хаягдлаа ангилан ялгах нь байгаль орчин, эдийн засаг, нийгэмд таны төсөөлснөөс ч илүү зэрэг нөлөөг бий болгодог.

1. ХОГНЫ ХЭМЖЭЭ БУУРНА

Дахин боловсруулснаар хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээ буурч хогийн цэгийн эзлэх талбайг 10-20%-иар багасгах боломжтой. Энэ нь хогийн цэгээс шалтгаалан бий болох агаар, хөрс, усны бохирдлоос сэргийлнэ.



2. ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛНА

Дахин боловсруулсан материалыг ашиглах нь түүхий материалын олборлолт ба үүнээс үүдэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасна.



3. ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭНЭ

Зөвхөн нэг кг ундааны савыг дахин боловсруулснаар 13W-ын чийдэнг 20 хоног тасралтгүй асаах эрчим хүчийг хэмнэдэг байна.



4. БАЙГАЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦИЙГ ХЭМНЭНЭ

Байгалиас олборлож буй бүх төрлийн ашигт малтмал, газрын ба ойн баялаг, түүхий эдийг хэмнэхээс гадна ус, ургамал, амьтад, хуурай газрын ашиглалтыг бууруулдаг. Байгалийн хязгаарлагдмал нөөцийг хэмнэх нь биологийн олон янз байдлыг хамгаалж, ирээдүй хойчдоо хэрэглэх нөөцийг нь үлдээх хариуцлагатай үйлдэл юм.



5. АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛДЭГ




Дахин боловсруулах салбар олон шинэ ажлын байрыг бий болгодог.

7. ОЛОН ТӨРЛИЙН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛНЭ



Хог хаягдлаас ялгарах хортой бодисууд нь амьсгалын зам, зүрх судас, хоол боловсруулах эрхтэн, харшил болон архаг хууч өвчлөлүүдийг үүсгэх эрсдэлтэй байдаг. Хог хаягдал нь нийгмийн сэтгэл зүйд ч сөргөөр нөлөөлдөг.

9. НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛОО ХАДГАЛНА



Монголын нүүдэлчин соёлд байгальдаа хог хаягдалгүй, экологийн ул мөр багатай амьдарч ирсэн түүхтэй. Энэ ёс заншил, ухааныг сэргээж үр хойчдоо өвлүүлэн уламжилна.

6. ГҮНИЙ УСЫГ ХАМГААЛДАГ



Үүсэх эцсийн хог хаягдлын хэмжээг бууруулах учраас хөрс цаашлаад гүний усанд нэвчиж болзошгүй бохирдлоос сэргийлж чадна.

8. ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХУРДАСГАНА



Хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах нь тогтвортой ирээдүйг бүтээх технологийн дэвшлүүд бий болоход дэмжлэг болно.

10. БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ НОТОЛНО



Байгаль орчин, нийгмийн өндөр хариуцлагатай болохоо харуулснаар байгууллагын нэр хүнд хөрөнгө оруулагч болон харилцагчдын дунд өсөх шалтгаан болно.

ХОГОО ХЭРХЭН АНГИЛАХ ВЭ?

Дахин боловсруулах үйлдвэр нь хог хаягдлыг нарийн ангилахыг шаарддаг боловч дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ажлын байран дээр дөрвөн үндсэн ангиллаар (цаас, хуванцар, шил, лааз) ялгаж болно. Аль болох олон хүмүүс, байгууллагуудыг оролцуулахын тулд эхлээд хялбар үйлдлүүдээс эхлэх нь зүйтэй.



- УС УНДАА
- ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
- ЭМ, ВИТАМИН
- БУСАД **PET** ГЭСЭН ТЭМДЭГТЭЙ ХАТУУ ХУВАНЦАР САВЛАГААНУУД



- ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН
- ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
- БУСАД **HDPE** ГЭСЭН ТЭМДЭГТЭЙ ХАТУУ ХУВАНЦАР САВЛАГААНУУД



- СУНАЖ УРАГДДАГ ГЯЛГАР УУТНУУД
- ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
- **LDPE** ГЭСЭН ТЭМДЭГТЭЙ УЯН САВЛАГААНУУД





- БИЧГИЙН ЦААС
- КАРТОНОН ХАЙРЦАГ
- 00-Н ЦААСНЫ ГОЛ
- ЕВАРИМТ-НЫ ЦААС



- УНДАА ЛААЗ
- ПИВОНЫ ЛААЗ



- БҮХ ТӨРЛИЙН ШИЛ /МАШИНЫ ШИЛНЭЭС БУСАД/



ШОШГО БОЛОН ЦАВУУГ АРИЛГАХ, ДОТОРХ НЬ ЦЭВЭРХЭН БАЙХ, ХЭМЖЭЭГ НЬ БАГАСГАХ, ТАГИЙГ НЬ АВАХ

ШОШГО БОЛОН ЦАВУУГ АРИЛГАХ, ДОТОРХ НЬ ЦЭВЭРХЭН БАЙХ

ШОШГО БОЛОН ЦАВУУГ АРИЛГАХ, ДОТОРХ НЬ ЦЭВЭРХЭН БАЙХ, ШАРЧИГНАДАГ БИШ БАЙХ

ӨӨХ ТОС БОЛЖ БОХИРДООГУЙ БАЙХ, ШОХОЙГУЙ ЦААС

ЗӨВХӨН ХӨНГӨН ЦАГААН ЛААЗ

ШОШГО БОЛОН ЦАВУУГ АРИЛГАХ, ДОТОРХ НЬ ЦЭВЭРХЭН БАЙХ

АНГИЛСАН ДАХИВРАА ХААНА ТУШААХ ВЭ?

Ангилсан дахивраа дараах алхмуудын дагуу тушаана.



АЛХАМ 1

Юуны өмнө ангилсан дахиврыг байршуулж хадгалах хогийн савыг бэлдэх хэрэгтэй. Хэрэв ангилах дахивар хогны савгүй бол Улаанбаатар Хотын Захирагчийн Ажлын Албанаас хэрэгжүүлж буй “Хогоо ангилах хөдөлгөөн” (<https://www.facebook.com/hogooangilya>)-ий 70002444 утсаар дэлгэрэнгүй мэдээллийг аваарай.

АЛХАМ 2

Хог хаягдлаа ангилж цуглуулсны дараа танай байгууллагын хог хаягдлыг тээвэрлэдэг байгууллага/холбогдох албан тушаалтанд хандаж, ангилсан хог тээвэрлэх ажлыг зохион байгуулах боломжтой эсэхийг шалгаарай.



АЛХАМ 3

Хэрэв дээрх алхам боломжгүй бол ангилсан дахиврыг дараах компаниудад хандаж тээвэрлүүлээрэй.

Энэ тохиолдолд тээвэрлэлтийн үнэ болох 30,000-40,000 төгрөгийг тус төвд тушаах бөгөөд овор хэмжээ хамаарахгүй ачилт хийх боломжтой. Энэ тохиолдолд дэргэдэх барилга байгууламжаа хогоо ангилахад уриалж, хамтарч дахивар цуглуулбал тээврийн үнийг хувааж төлөн хэмнэж болно. Бүх төрлийн дахиврыг овор хэмжээ хангалттай хэмжээнд хүртэл (1тн шуудай дүүрсэн) хуримтлуулсан тохиолдолд дараах дахивар нөөцийн цэгүүдэд хандаж үнэгүй тээвэрлүүлэх боломжтой. Үүнд:

БЗД, СБД Дахивар нөөцийн цэг №1

☎ 8870-4841

СХД-т Дахивар нөөцийн цэг №9

☎ 99991712

ЧД-т Дахивар нөөцийн цэг №82

☎ 88709002

ХУД-т Дахивар нөөцийн цэг №10

☎ 88165252

НД-т Дахивар нөөцийн цэг №59

☎ 88080373

ШИЛ, ЛААЗ, ХУВАНЦАР

"Мог Пластик" ХХК

f [fb.com/mogplastic](https://www.facebook.com/mogplastic)

☎ 88773223, 80076550

(Дахиврын овор хэмжээнээс хамаарч төлбөрийг тус компанитай тохиролцоно.)

КАРТОН ЦААС

Эко Сити Селекшн" ХХК

f [fb.com/profile.php?id=100072659794415](https://www.facebook.com/profile.php?id=100072659794415)

☎ 98112689, 86818123

(Дахиврын овор хэмжээнээс хамаарч төлбөрийг тус компанитай тохиролцоно.)

БҮХ ТӨРЛИЙН ДАХИВАР

"Төвшин Сайхан Төв"

f [fb.com/tuvshinsaikhancenter](https://www.facebook.com/tuvshinsaikhancenter)

☎ 96685858

АЛХАМ 4

Дахивраа тушаах өөр нэг арга бол өөрсдөө ойр байрлах дахивар нөөцийн цэг рүү хүргэж өгөх юм. Хэрэв та өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн бол тушаасан дахиврын төлбөрийг авах болно.



ХОГ ХАЯГДЛАА БУУРУУЛАХ АРГУУД

Худалдан авалтандаа 5R алхмыг ажлын байран дээрээ хэрэгжүүлэх нь хог хаягдлыг бууруулах, байгууллагын нөөцийг хэмнэх чухал арга хэмжээ юм.



ТАТГАЛЗАХ (REFUSE)

Худалдан авахаас татгалзах нь хог хаягдлыг бууруулах хамгийн үр дүнтэй арга юм. Жишээлбэл, үзэсгэлэн худалдаа, хурлууд дээр тараагддаг үнэгүй бүтээгдэхүүнээс татгалзах, мөн оффис дээр нэг удаагийн хэрэгслүүд, хуванцар сав, хоолны сав зэргээс татгалзаж болно.

БАГАСГАХ (REDUCE)

Хэрэв татгалзах боломжгүй бол хэрэглээг багасгах нь дараагийн зөв алхам болно. Хог хаягдал үүсгэдэг бүтээгдэхүүний хэрэглээг бууруулснаар та хог болох зүйлсийг багасгахад туслах болно. Ажлын байранд хог хаягдлыг бууруулах дараах зөвлөмжийг дагаарай:

- Цаасны хэрэглээгээ багасгах,
- Оффисын хэрэгслийг бөөнөөр худалдаж авах, сав баглаа боодол багатай эсвэл савлагаагүй зүйлс хэрэглэж хэвших,
- Оффисын цэвэрлэгээний хангамжид хоргүй, био задралд сайн ордог органик зориулалттай цэвэрлэгээний бүтээгдэхүүн авч хэвших,
- Эрчим хүч болон усны хэрэглээг хэмнэх,
- Байгууллагын түвшинд мөн ажилтнууддаа ногоон тээврийн хэрэгсэл хэрэглэхийг уриалах г.м.



ДАХИН АШИГЛАХ (REUSE)

Шинээр бараа бүтээгдэхүүн худалдаж авахаас илүү оффис дээр байгаа зүйлсээ дахин ашиглах нь тогтвортой байдлыг хэрэгжүүлэх бас нэгэн арга юм. Бүтээгдэхүүн худалдаж авахдаа нэг удаагийн бус харин дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүн авах тал дээр анхаарлаа хандуулаарай. Мөн дараах аргуудыг анхааралдаа аваарай:

- Хуванцар савны оронд дахин ашиглах боломжтой усны аяга эсвэл шилийг сонгох,
- Принтерийн хорыг шинээр худалдаж авахын оронд эцсийн хэрэглээ хүртэл цэнэглэх,
- Байгууллагад ирсэн хайрцаг, баглаа боодлын материалыг дахин ашиглах
- Цаасан салфеткын оронд оффисын гал тогоонд зориулсан гар алчуур худалдаж авах,
- Оффисд хэрэггүй зүйлсийг хандивлах боломжтой бол хог үүсгэхээс сэргийлж хандивлаарай. Ингэснээр өөр хүмүүс үүнийг дахин ашиглах боломжтой болох юм.



ЗАСАЖ СЭЛБЭХ, СЭРГЭЭН АШИГЛАХ (REPURPOSE)

Сэргээн ашиглах нь тогтвортой байдлын 5R зарчмын өөр нэгэн арга юм. Та ямар нэг зүйлийг өөр зориулалтаар дахин ашиглаж болно. Жишээлбэл, хүүхдэд зориулсан гар урлалын зориулалтаар оффисын картон хайрцаг, цаас болон бусад зүйлсийг гэртээ авч явах г.м. Хогийн саванд хаядаг зүйлүүддээ бүтээлчээр хандахад л оффисын хаягдлыг тогтвортой байдлаар сэргээн ашиглахад тустай байх болно.



ДАХИН БОЛОВСРУУЛАХ (RECYCLE)

Энэ нь хог болохоос сэргийлэх эцсийн арга юм. Энэ нь дахин боловсруулах боломжийг дэмжих буюу хог хаягдлаа ангилан ялгахыг хэлнэ.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЯГ, ХОЛБООСУУД

I. ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ААН-ҮҮД

№	Үйлдвэрийн нэр	Хүлээн авч буй хаягдал хуванцрын төрөл	Бүтээгдэхүүн	Утас
1	"Од пластик" ХХ	HDPE, PE, LDPE	HDPE үрэг хогны уут	99028866
2	"Хэв хашмал хуванцар" ХХК	HDPE, PP, PE	PP, PE үрэг, барилгын хэв хашмал, гэр ахуйн бараа, сувинер	99823222
3	"Ансэхэ" ХХК	HDPE, PE, PP	Цахилгааны хамгаалалтын хоолой, (HDPE)	99111964
4	"Сэртэн хангай" ХХК	HDPE, PE, LDPE	HDPE үрэг хогны уут	91913358
5	"Метро пласт" ХХК	HDPE, PP	Вакум цонх, цэвэр бохир усны хоолой	99110360
6	"Сан-Оргиу" ХХК	PE, LDPE	Сандал, траншейний таг, подон, хайс, шон	99093849
7	"Идэр ивээлт" ХХК	HDPE, LDPE	HDPE үрэг, хогны уут	88940094
8	"Пластик центр" ХХК	LDPE, PE	Нүхэн жорлонгийн сав, худаг, шилжүүлэгч таг, траншейний таг, бүх төрлийн цутгамал хуванцар	88104308
9	"Тэр Их Нуур" ХХК	PVC	Бохирын болон, усны хоолой	91917077, 98087077
10	"Ти Эм Эл" ХХК	PET, LDPE, HDPE, лааз, картон цаас, хөнгөн цагааны хайлш	Ипорт орлох PET, хуруу шилэн бэлдэц	88881399
11	"Мултипак" ХХК	LDPE, PE	Багцлагч уут /пакет/	99119078
12	"Сод Түм" ХХК	HDPE, PE, PP	Цахилгааны хамгаалалтын хоолой, (HDPE)	99137896

№	Үйлдвэрийн нэр	Хүлээн авч буй хаягдал хуванцрын төрөл	Бүтээгдэхүүн	Утас
13	"Түмэн эгшиг" ХХК	LDPE, HDPE, PP шуудай	Хагас бэлдэц	99110428
14	"ОБ Пластик" ХХК	LDPE, PE	Гялгар уут, хэвлэлтэй болон багцлагч уут, сав баглаа боодол	99114200
15	"Цэцүүх Трэйд" ХХК	HDPE, HDPE, PP, PE	Хуванцар үрлэн түүхий эд үйлдвэрлэдэг	99112108
16	"Грийн Пластик ЮБ" ХХК	LDPE, PE	Хогны уут, сав баглаа боодол үйлдвэрлэдэг	91039003
17	"ЖБС" ХХК	LDPE, PE	Багцлагч уут /пакет/	88680033
18	Инахис ХХК	Хаягдал дугуй	Резинэн хавтан	99115097
19	Пийс Стийл Групп ХХК	Хөнгөн цагаан, хайлш дахин боловсруулах	Усан онгоцны жин тэнцвэржүүлэгч	9958808
20	МСРТ ХХК	Хаягдал мод дахин боловсруулах	Шорлогны түлш	99115011
21	Хай би ойл ХХК	Моторын хаягдал тос	Моторын масло, М-100мазут	88119740
22	Мон Пити Ойл ХХК	Моторын хаягдал тос	М-100 мазут	99054755
23	Алтайн Харгиа ХХК	Хаягдал арьс шир	Халиман цавуу	99116508
24	Эко тайхи ХХК	Төв цэвэрлэх байгууламжийн лаг	Компост бордоо	80102022
25	Ногоон газар трэйдинг ХХК	Хаягдал хөөсөнцөр дахин боловсруулах	Полистрол хавтан, блок	99118514
26	Ти Жэй Эн Ресайклин ХХК	Органик хог хаягдал дахин боловсруулах	Компост бордоо	88880150
27	Үлэмж хүдэр ХХК	Хаягдал хар тугалган аккумулятор	Хар тугалган гулдмай	99089969
28	Алтан Оршихуй ХХК	Моторын хаягдал тос	Дизель түлш, М-100 мазут	99774277

II. ЗАРИМ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД, ОЛОН НИЙТИЙН БҮЛГҮҮДИЙН СОШИАЛ ХОЛБООСУУД

Монголын Тогтвортой
Хөгжлийн Гүүр

☎ 8000 3489
f /MongolianSustainableDevelopmentBridge

Каритас Чех Репаблик

☎ 7013 5899
f /CaritasCzechRepublicInMongolia

Экосум ТББ

☎ 8014 2043
f /Ecosoum

Монголын Хог Хаягдлыг Дахин
Боловсруулах Үндэсний Холбоо:

☎ 8911 6570
f /MongolianNationalRecyclingAssociation

Монголын Хуванцар Дахин
Боловсруулагчдын Холбоо

☎ 9982 3222

Монголын Аюултай
Хог Хаягдлын холбоо

☎ 7017 0399
f Аюултай Хог Хаягдлын Холбоо
t /monhazardous

Өнгө Нэм

☎ 9900 2058
f /UnguNem

Хоггүй Монгол ТББ

☎ 9510 4373
f /NoPlasticMongolia

Ногоон Сэтгэе Клуб

☎ 8088 1308
f /ThinkGreenMongolia

Хогоо багасгая бүлгэм

f /groups/2127875217449095

Хогоо ангилья бүлгэм

f /groups/HogooAngiljUnguNem

Зеро Вэйст Монголиа

☎ 8000 3489
f /Zero-Waste-Mongolia-1840169412869327

Zero Waste Club

☎ 9983 3629
f /ZerowasteClubMn

Хогоо эх үүсвэр дээр нь
ангилж хэвшье

☎ 7000 2444
f /groups/1651914868202992

3R4UB

f /3R4UB

Улаанбаатар хотын Ахуйн Хог
Хаягдлын Цуглуулалт,
Тээвэрэлтийн Менежмент төсөл

☎ 7011 1220, f Эерэг давалгаа – UB Waste


Улаанбаатар Хүнсний Хог
Хаягдлыг Дахин Боловсруулах төсөл

globe www.ubfoodwaste.mn

Хогоо ангилах хөдөлгөөн

☎ 9910 1315 f Хогоо ангилах хөдөлгөөн



 Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Делта төв 5 давхар, 503 тоот

 ccr.mongolia.office@caritas.cz

 +976 7013 5899

 www.mongolia.charita.cz

 fb.com/CaritasCzechRepublicInMongolia